



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2001 оны 7 дугаар
сарын 31 ны өдөр

Дугаар 247

Уг шийдвэрийг
хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2001 оны 7 дугаар сарын 18, 2000 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. 1999 оны шилдэг оюутан Даваасүрэн овогтой Бамбарыг Япон улсын Тохокүгийн Их сургуулийн магистрантурт физик химийн чиглэлээр, Жанчивнямбуу овогтой Энхбаярыг АНУ-ын "Галлаудет" Их сургуулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр, Нарантуяа овогтой Туяаг АНУ-ын "Сэлисбури" Их сургуулийн магистрантурт боловсрол судлалын чиглэлээр тус тус 2001-2002 оны хичээлийн жилээс 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. ОХУ-ын Москва хотын Найрамдлын Их сургуулийн аспирантурт суралцаж буй Дэмбэрэл овогтой Нямцэрэнгийн эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг зээлээр олгосугай.

3. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /В.Ганбат/-д, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Гадаадад суралцуулах тухай" Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2000 оны 54 дүгээр тушаалын 1-т бичигдсэн Нарантуяа овогтой Туяаг суралцуулах тухай заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД-г

В. Ганбат
Хүндэтгэл
Гүйцэтгэл
Байна

А.ЦАНЖИД